



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

АДААЦАГ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.ЭНХТУУЛ ТАНАА

2017.02.09 № 01/10 АУА-2017/13/СТА-ТНЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчин үндсэн хөрөнгийн шинж чанартай 286,000.00 төгрөгийн үнэтэй цаг бүртгэлийн төхөөрөмж худалдан авч, зардалд тайлагнасан байна.
2. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас зориулалт бусаар цалингийн зардалд 169,818.00 төгрөгийг шилжүүлсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ Сангийн сайдын 55 дугаар тушаалын 6 дугаар хавсралтад заасан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-т /байгууллагын ажлын байрны тохижилт, цэвэрлэгээ болон аж ахуйн хэрэгцээний зориулалтаар худалдан авсан бараа материал, эд зүйлс тухайлбал угаалгын нунтаг, цай, сахар гэх мэт бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийг худалдан авч шууд зарлагадах зардлыг энэ ангилалд бүртгэнэ... /, /хуульд заасан хувь хэмжээгээр үндсэн болон нэмэгдэл цалин, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тооцож энэ ангилалд бүртгэнэ/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:


999000020

1. Батлагдсан төсвийг зарлагын эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцуулж байх, цаашид холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ж.Энхтуул, нягтлан бодогч Ө.Уранбилэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

ШИНЖЭЭЧ



Ж.УГТАХБАЯР


ЭРХЛЭГЧ

ЗӨВШӨӨРСӨН:

Ж.ЭНХТУУЛ

НЯГТЛАН БОДОГЧ

Ө.УРАНБИЛЭГ



¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/